# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр | Дугаар 483 | Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Барилга, хот байгуулалтын сайдын багц) бий болсон нийт 17,923,929,832.00 (арван долоон тэрбум есөн зуун хорин гурван сая есөн зуун хорин есөн мянга найман зуун гучин хоёр) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон хавсралтад заасан аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132003412

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дүгээр сарын ......02......-ны өдрийн
......123...... дугаар тогтоолын хавсралт

**Улсын төсвийн хөрөнгө оруулалт /Барилга, хот байгуулалтын сайдын багц/-аар бий болсон барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт**

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Эхлэх, дуусах хугацаа | | Төсөл, арга хэмжээний хүчин чадал | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Төсөвт өртөг /сая.төг/ | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/ | Бүртгэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар** | | | | | | | | | | |
| 1 | Зуунмод хотын 2*2000 м3 багтаамжтай усан сан, усан хангамжийн шугам сүлжээ | 2018 | 2022 | 2*2000 м3 багтаамжтай усан сан, 9600 м шугам сүлжээ | 9/24/2020 | м | 9600 | 2,700.0 | 2,688,151,433.00 | Төв аймгийн "Төв чандмань" ДЭХГ |
| **Хэсгийн дүн** | | | | | | | | | **2,688,151,433.00** | |
| **Нийслэлийн өмчийн харилцааны газар** | | | | | | | | | | |
| 2 | "Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/ | 2020 | 2022 | Дулааны алдагдалтай 300 өрхийн айлд дулаалга, эко жорлог, цахилгаан халаалт 2.5-6.5 квт хүчин чадал бүхий | 9/9/2021 | м2 | 3250 | 8,000.0 | 7,443,846,043.0 | Нийслэлийн ЧД-ийн ЗДТГ |
| 3 | "Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 23, 39дүгээр хороо/ | 2020 | 2022 | Дулааны алдагдалтай 58 өрхийн айлд дулаалга, эко жорлон цахилгаан халаалт 2.5-6.5 квт хүчин чадал бүхий | 2/15/2022 | квт | 2.5-6.5 | 1,150.0 | 1,142,859,657.0 | Нийслэлийн СХД-ийн ЗДТГ |
| 4 | Гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 4, 5, 14 дүгээр хороо/ | 2020 | 2021 | м2 тохижилтын ажил | 11/19/2021 | м2 | | 600.0 | 587,688,028.0 | Нийслэлийн БЗД-ийн ЗДТГ |
| 5 | Инженерийн шугам сүлжээний зураг, төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2021 | 2022 | Инженерийн шугам сүлжээний зураг, төсөв | 4/22/2022 | ш | 1 | 800.0 | 792,376,500.0 | Нийслэлийн БГД-ийн ЗДТГ |
| **Хэсгийн дүн** | | | | | | | | | **9,966,770,228.00** | |
| **Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газар** | | | | | | | | | | |
| 6 | Ундны усны худаг /Архангай, Хангай, Жаргалант, Тариат, Цахир сум/ | 2020 | 2022 | Худгийн гүн-70м, ундарга 1.2 л/с | 11/20/2021 | м | 70 | 180.0 | 173,529,253.0 | Архангай аймгийн ЗДТГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Сумын төвийн шинэчлэл төлөвлөлтийн зураг төсөв /Архангай, Ихтамир сум/ | 2020 | 2020 | инженерийн барилга байгууламжийн судалгаа техник эдийн засгийн үндэслэл | 7/7/2021 | ш | 1 | 100.0 | 96,250,000.0 | Архангай аймаг Ихтамир сум |
| 8 | Сумын төвийн шинэчлэл /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/ | 2020 | 2021 | 60 м3 хоног хүчин чадал усан сан, 50 м3 цэвэрлэх байгууламж, 0.8 км авто зам, 1008 м гадна дулаан, 1238 м цэвэр усны шугам 2989 м бохирын шугам | 11/30/2021 | шугам /м/ | 5235 | 4,750.0 | 4,710,230,918.0 | Архангай аймаг Эрдэнэмандал сумын ЗДТГ |
| 9 | | | | | | усан сан /м3/ | 60 | | | |
| 10 | | | | | | авто зам /км/ | 0.8 | | | |
| **Хэсгийн дүн** | | | | | | | | | **4,980,010,171.00** | |
| **Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар** | | | | | | | | | | |
| 11 | Сумын төвийн инженерийн барилга байгууламжийн судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл /Хөвсгөл, Мөрөн сум/ | 2020 | 2022 | инженерийн барилга байгууламжийн судалгаа техник эдийн засгийн үндэслэл | 7/7/2021 | ш | 1 | 300.0 | 288,998,000.0 | Хөвсгөл аймгийн ЗДТГ |
| **Хэсгийн дүн** | | | | | | | | | **288,998,000.00** | |
| **Нийт дүн** | | | | | | | | | **17,923,929,832.00** | |
| | | | | | | | | | **(арван долоон тэрбум есөн зуун хорин гурван сая есөн зуун хорин есөн мянга найман зуун гучин хоёр төгрөг)** | |